

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ҮГ

ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс 44 дэх жилдээ тасралтгүй эрхлэн хэвлүүлж буй “Олон улс судлал” сэтгүүл нь Монгол Улсад гадаад орон судлал, олон улсын харилцааны чиглэлээр гардаг сэтгүүлүүдээс мэргэжлийн хянан магадлагаа хийдэг, эрдэм шинжилгээний бүтээлийн олон улсын нэгдсэн DOI (Digital Object Identifier) дугаар олгодог салбартаа анхны эрдэм шинжилгээний сэтгүүл юм.

1978-1999 оны хооронд “Өрнө, Дорно”, “Дорно дахины асуудал”, “Дорно дахины судлалын асуудал”, “Зүүн хойт Ази судлал” гэх бүс нутаг судлалын хүрээний асуудлыг хөнддөг сэтгүүл байснаа хүрээлэнгийн бүтэц, зохион байгуулалт, судалгааны чиглэл өргөжихийг дагалдан 2000 оноос хойш “Олон улс судлал” нэрээр гарч агуулга, цар хүрээ нь өргөжсөн юм.

Манай сэтгүүл уламжлалт цаасан суурьтайгаар хэвлэгдэхээс гадна сүүлийн жилүүдэд тогтмол цахим хувилбараар давхар тархагддаг болсоноор хүртээмж нь эрс нэмэгдэж, өгүүлэл материалаа ирүүлэх судлаачид болон өргөн олон уншигчдын анхаарал сонирхлыг улам ихээр татдаг болжээ. Зөвхөн <https://www.mongolijol.info>-д байршуулсан сүүлийн зургаан дугаарт дэлхийн өнцөг булан бүрээс нийтдээ 150 мянга гаруй удаа хандсан байна. Манай сэтгүүлд хэвлэгдсэн бүтээлүүд

эрдэм шинжилгээний хүрээнд эрэлт, хэрэгцээ ихтэй байгааг тэдгээр дугаарт хэвлэгдсэн өгүүлүүдийг татаж авч ашигласан тоон үзүүлэлт мөн гэрчилнэ. Энэ мэтээр олон улс, орон судлалын салбарын судалгаа, шинжилгээний орчинд манай сэтгүүл өөрийн гэсэн орон зайгаа нэгэнт эзэлсэн ба салбарынхаа судалгааг хөгжүүлэх үйлсэд ч зохих хувь нэмрийг оруулсаар байгаа юм.

Үүний зэрэгцээ бид сэтгүүлийнхээ цаасан сууриар хэвлэгдсэн өмнөх бүхий л дугааруудыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эрчимтэй өрнүүлж дууслаа. Иймийн учир 1978-1999 оны дугааруудыг www.mori.ac.mn нээлттэй цахим мэдээллийн сангаас, сэтгүүлийн сүүлийн дугааруудыг <https://www.mongolijol.info/index.php/JIS> цахим хуудсаас бүтнээр үзэж, ашиглах боломжтой болсон гэдгийг Та бүхэнд дуулгахад таатай байна.

Энэ удаагийн 112 дахь дугаарт гадаад харилцааны мэргэжилтнүүд, эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан, их сургуулийн багш, докторант зэрэг дотоод, гадаадын судлаачдын бичсэн 10 өгүүлийг эрхэм уншигч Таны мэлмийд өргөн толилуулж байна.

Сэтгүүлийн редакц энэ удаагийн дугаарт эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авах хугацаандаа нийтдээ 17 өгүүлэл зохиогчдоос хүлээн авсан

бөгөөд редакцын анхан шатны үнэлгээ, хөндлөнгийн шинжээчийн санал, редакцын зөвлөлийн хуралдааны шийдвэр гэсэн гурван шатны үнэлгээнд үндэслэн редакцын анхан шатны үнэлгээгээр 4 өгүүлэл, хөндлөнгийн шинжээчийн саналаар 2 өгүүлэл, редакцын зөвлөлийн хурлын шийдвэрээр 1 өгүүлэл, нийт 7 өгүүлийг энэ удаагийн дугаарт хэвлэх боломжгүй талаар зохиогчид нь мэдэгдэж буцаасан болно.

Сэтгүүлийг эрхлэн гаргах хугацаанд нэр бүхий 6 хөндлөнгийн шинжээч ажиллаж, давхардсан тоогоор 15 удаа шүүмж ирүүлэв. Хэвлэгдэн гарч буй 10 өгүүлэл тус бүр хөндлөнгийн шинжээчийн шүүмжлэлийн дагуу сайжруулсан ба үүнээс 2 өгүүлэл давтан буцаж засварлагдсан болохыг онцлон тэмдэглэе. Бидний ажилд дэмжлэг үзүүлэн цаг заваа харамгүй зориулан үнэтэй шүүмж ирүүлсэн шинжээчиддээ Редакцын зөвлөлийн гишүүдийн өмнөөс болон Ерөнхий редакторын зүгээс гүн талархал илэрхийлж байна.

Энэ удаагийн дугаарт нийтлэгдэж буй өгүүллүүд Монгол-Олон улсын хамтын нийгэмлэгүүдийн хийгээд Монгол-Хятадын харилцаа, харилцааны түүх, ОХУ, БНХАУ-ын дотоод асуудал, цар тахалын үеийн улс орнуудын нөхцөл байдал, Монгол Улсын гадаад харилцаанд холбогдох асуудал, гадаадын монголч эрдэмтний судалгаа зэргийг хөндөн бичигджээ. Мөн номын шүүмж нэг, шинэ номын танилцуулга хоёр багтав.

Редакцын зүгээс профессор

Д.Баярхүүгийн цаг үеийн чухал сэдвийг хөндөн бичсэн “Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч Х.Баттулгын гадаад бодлого, түүний онцлог” өгүүлийг онцолж байна. Мөн Монгол Улсын гадаад харилцааны түүхийн судалгаанд холбогдох хоёр өгүүлэл хэвлэгдсэний нэг нь ХХ зууны манай улсын гадаад бодлогын оргил амжилт болох НҮБ-д элсэн орсон зангилаа асуудлыг хөндсөн “НҮБ-д Монголын асуудлыг хэлэлцсэн нь (1946-1961 он): БНМАУ-ын гишүүнчлэлийн асуудлаарх ЗХУ, АНУ-ын байр суурийн хувьсал өөрчлөлт” хэмээх академич Ц.Батбаярын бичсэн өгүүлэл болно. Ц.Батбаяр “Хүйтэн дайн”-ы нөхцөлд НҮБ дахь Монголын асуудлаар ЗХУ, АНУ зэрэг их гүрнүүдийн байр суурь, тэдний зөрчил, сөргөлдөөн, эвлэрлийн уялдаа холбоог задлан шинжилжээ. Залуу судлаач Бөхөө “Социализмын үеийн Монгол, Хятадын түүх судлалын харилцаа: Ойлголцол ба зөрчил (1950-иад он)” өгүүлэлдээ БНМАУ, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны дараах 10 орчим жилийн хугацаанд хоёр улс социалист орнуудын хувиар түүхэн материализмын онол хийгээд пролетарийн интернационализмын зарчмыг үзэл баримтлал болгосон ойлголцлын үндсэн дээр хамтран түүх судлалыг хөгжүүлэх гэсэн оролдлогын тухайд тусгайлан өгүүлжээ.

Түүнчлэн хоёр орны орчин цагийн харилцаанд холбогдох “Монгол-Хятадын хилийн Сүмбэр-Рашаан боомт: Өнөөгийн байдал, хөгжлийн боломж” өгүүлэлд доктор Алтан, Д.Базардорж нар Сүмбэр-Рашаан

боомтын өнөөгийн байдал, хөгжлийн төлөв хандлага ба төр засаг болон орон нутгаас баримталж буй хөгжлийн бодлогын уялдаа холбоо, түүнийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодруулж, цаашид сайжруулах талаарх судлаачийн байр сууриа илэрхийлсэн байна.

Тус хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор М.Эрдэнэбаярын БНХАУ-ын үндэсний эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх XIV таван жилийн төлөвлөгөөг шинжилсэн “БНХАУ-ын шинэ таван жилийн төлөвлөгөө, эдийн засгийн бодлогын өөрчлөлт” өгүүлэл хэвлэгдэв. Хятадын шинэ таван жилийн төлөвлөгөөний голлох зорилт, стратеги, онцлог, тус улсын эдийн засгийн хөгжлийн бодлогод гарч буй өөрчлөлтөд хийсэн дүн шинжилгээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тулгарч болох сорилт, биелэгдэх боломж, улмаар Монгол Улсын эдийн засагт үзүүлж болох нөлөө, анхаарах асуудлын тухайд зохиогч санал бодлоо хуваалцжээ.

Мөн хүлэмжийн хийг бууруулах зорилтын хүрээнд манай улсын эрчим хүчний салбарт тулгамдаж буй гол гол асуудлыг хөндөж, цаашид авч хэрэгжүүлэх боломж, гаргалгааг тодорхойлохыг зорьсон өгүүллийг тус салбарын эрдэм шинжилгээний ажилтан, БНХАУ-ын Фуданий их сургуулийн докторант Х.Сэлэнгэ “Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах боломж, тулгарч буй сорилт (Эрчим хүчний салбарын жишээн дээр)” нэртэйгээр хэвлүүлэв.

Орос судлалын хүрээнд хүрээлэнгийн залуу судлаач, магистр Д.Туул “ОХУ-ын Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад нөлөөлсөн хүчин зүйлс, Үндсэн хуульд тусгалаа олсон байдал” өгүүлэлдээ ОХУ-ын Үндсэн хуулийн сүүлийн өөрчлөлт Үндсэн хуульд бодитоор хэрхэн тусгалаа олсныг авч үзэхээс гадна ОХУ-ын улс төр, засаглалын тогтолцоо, хүн ам, нийгмийн харилцаанд тусах нөлөөг Оросын болон барууны улс төр, эрх зүйн чиглэлийн судлаачид хэрхэн тайлбарлаж буйг харьцуулан үзэж судлаачийн зүгээс дүгнэхийг зорьсон байна.

Түүнчлэн, Монгол Улсын “гуравдагч хөрш” орны нэг АНУ-ын гадаад бодлогын асуудлыг хөндсөн “Энэтхэг-Номхон далайн стратегийн хүрээнд Америк-Оросын харилцаанд гарч болзошгүй өөрчлөлтийг шинжлэх нь” хэмээх докторант Ц.Буянцогтоо, генерал О.Үржин нарын өгүүлэл багтаж байна. Уг өгүүлэлд Америк-Оросын харилцаанд гарч болзошгүй өөрчлөлтийн талаар олон улсын харилцааны реализмын онол, геополитик, стратеги судлалын онолд тулгуурлан сонирхолтой шинжилгээ хийсэн байна.

Мөн судлаач Н.Гэрэлт-Од цар тахал улс орнуудын манлайлал, засаглалын ялгаатай байдал, онцлог арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа улс орнуудын цар тахлын менежментийн кэйсийг харьцуулан судалсан “Улс орнуудын цар тахалтай тэмцэж буй арга барил, засаглалын чадамж” өгүүллээ толилуульж байна.

Энэ жил Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жил ой тохиож буй. Иймээс бид ОХУ-ын Байгалийн их сургуулийн профессор, доктор (Sc.D) Ю.В.Кузьмин, МУИС-ийн профессор, доктор (Sc.D) Ж.Урангуа нарын хамтран бичсэн “Монголч эрдэмтэн Н.П.Шастина” өгүүллийг нийтэлсэн бөгөөд өгүүллийн зохиогчид ЗХУ-ын эрдэмтэн Н.П.Шастина (1898-1980)-гийн Монгол судлалын талаар хийсэн бүтээлүүдийн үзэл санаа болон бүтээл туурвилын намтар түүхийг дэлгэн тавьсан байна.

Манай сэтгүүлийн дараагийн дугаарт өгүүллээ хэвлүүлэх хүсэлтэй

эрхэм уншигч, бичгийн мэргэд Та бүхэн <https://www.mongoliajol.info/index.php/index/user/register> хуудсанд өөрийн нэрээр эрх үүсгэн бүртгүүлж, судалгааны бүтээлээ илгээвэл Редакцын зөвлөл болон судлаач, хянан магадлагч нарын хамтын ажиллагаанд илүү хялбар, хөнгөн шуурхай байх болно гэдгийг анхааралдаа авахыг хичээнгүйлэн хүсье.

Сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдэлээ mjis@mas.ac.mn хаягаар ирүүлбэл бид ихэд талархана.

Сэтгүүлийн ерөнхий эрхлэгч